

АНУ-ЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Х.Баасандорж

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академийн Аюулгүй байдал судлалын төвийн дарга, дэд хурандаа

Товч агуулга: 1990 оныг хүртэл дэлхий ертөнц бүхэлдээ ЗХУ болон АНУ гэсэн хоёр туйлт дайсагнасан хүйтэн дайны нөхцөл байдалд оршиж байсан бөгөөд Берлиний ханыг нурааж ЗХУ задран унаснаар дээрх 2 их гүрний хооронд олон жил үргэлжилсэн хүйтэн дайн дуусгавар болж, дайсагнасан цэрэг зэвсгээр хөөцөлдсөн улс төрийн бодлого дуусгавар боллоо хэмээн хэн бүхэн хэлж ярьж бичиж байв. АНУ-ын дангаар ноёрхох их гүрний ноёрхлын бодлого энэ үеэс эхэлсэн бөгөөд өнгөрсөн 35 жилийн турш дэлхий нийтийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаа хэрхэвч энх амар амгалан байсангүй. Өнгөрсөн он жилүүдэд Персийн булангийн дайн, Иракийн дайн, Афганистаны дайн, Босны герцогавин дахь бөмбөгдөлт, Югослав дахь мөргөлдөөн, Ойрх дорнод дахь олон жилийн дайн тулаан, Украины дайн гэх мэт харин ч хүйтэн дайны үеэс дайн тулааны тоо статистик өссөн үзүүлэлттэй байна. Эндээс үзэхэд нэг туйлт ертөнцөд аль нэг дангаар ноёрхол тогтоогоод энх тайван амар амгалан тийм ч амар

ирдэггүйг бид харж болно. Тэр ч бүү хэл дэлхийд дангаар ноёрхож буй Америкийн нэгдсэн улс нь өөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй хилийн аюулгүй байдлаараа дамжуулан үндэсний аюулгүй байдлаа өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрхэн аажим аажмаар алдсан тухай товчхон сийрүүлэхийг оролдлоо.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, геополитик, улс төрийн бодлого

Үндсэн хэсэг

Даяаршил гэдэг үг хэллэгийг бид сонсох болоод багагүй хугацаа өнгөрсөн байх, товчхондоо даяаршил гэдгийг хүмүүс хүн төрөлхтөн хаана ч амьдарч болно, дэлхий хавтгай болсон, бид хаанаас ч онлайнаар суралцах боломжтой, хаана ч нүүж шилжиж амьдарч болно, тухайн хүний эрх, эрх чөлөөг ардчилал, хүний эрх гэсэн далбаан дор хангаж өгч байх ёстой, чөлөөт худалдаа, зах зээлийн эдийн засаг, өмч хувьчлал зэрэг ойлголтыг даяаршлын хүрээнд түгээмэл хэрэглэж байх шиг. Гэтэл сүүлийн жилүүдэд тэр тусмаа 2022 оны 02 дугаар сарын 22-нд Украины дайн эхэлсэнтэй холбогдуулан даяаршил, либерализм дуусгавар боллоо, АНУ-ын алтан үе дахин эргэж ирэхээргүй боллоо, Жое Байдены засгийн газар стратегийн маш том алдаа гаргаж ОХУ болон БНХАУ-ыг нэгтгэчихлээ зэргээр бичих барууны судлаачид цөөнгүй

үзэгдэх болов. Даяаршлыг даган тухайн улсад нутагшдаг хэвлэлийн эрх чөлөө, өмч хувьчлал, чөлөөт зах зээлийн эдийн засаг, LGBTQ нарын бодлогыг хүчтэй эсэргүүцэн шүүмжлэх жижиг, том цөөнгүй улсууд дэлхий дээр мэдэгдэл хийцгээх болсон нь үнэхээр ч дээр дурдсан барууны зарим судлаачдын хэлж, ярьж, бичиж байгааг батлах мэт. АНУ нь сүүлийн 35 жилийн хугацаанд дэлхийд дангаар жанжлах бодлого явуулахын зэрэгцээ чөлөөт зах зээлийн бодлогыг өөрөөсөө бусад улсад тулгах дээрэнгүй бодлого явуулж ирсэн бөгөөд үүгээр дамжуулан зарим улсын улсын үйлдвэрийн газруудын дээрэмдэн авч байсан нь нэгэнт ил болоод байгаа юм. Тэд өөрөөсөө бусад улсыг сулруулаад зогсохгүй өөрсдөө ч мөн адил бий болгосон механизмдаа “хордож” өөрийн орны хүүхэд залуусыг хар тамхинд донтох, олдмол бэлгийн гаж чиг хандлагатай болгох, хүний наймааны зах зээлийн хохирогч болох зэргээс хамгаалж чадахгүй байдалд хүрээд байгаа нь яахын аргагүй даяаршлын “ач гавьяа” гэж хэлж болох юм.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан намаас нэр дэвшигч Камала Харрис ялагдсан шалтгаан:

Өнгөрсөн оны 11 дүгээр сард дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн гэгддэг америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн ажиллагаа зохион

байгуулагдсан бөгөөд энэхүү сонгуульд ардчилсан намаас нэр дэвшигч Камала Харрис 226 төлөөлөгчийн санал авсан бол өрсөлдөгч Бүгд найрамдах намаас дахин нэр дэвшиж буй Д.Трампа 312 төлөөлөгчийн саналаар хол тасархай сонгуульд ялалт байгуулав. Камала Харрисыг дэмжихээр тус улсын еврей лобби бүлэг 1 тэрбум долларын хандив өргөөд байсан бол өрсөлдөгч Д.Трампад 380 сая долларын л хандив өгсөн нь олон нийтийг гайхшируулж байв. Ийм зөрүүтэй санхүүгийн дэмжлэгтэй байхад яагаад Камала ялагдчихав гэдгийг олон судлаач нар өөр өөрийн өнцгөөс тайлбарлаж байгаа бөгөөд хамгийн том шалтгаануудын нэгээр Камала хэт хожуу буюу 2024 оны 07 дугаар сард л гэнэт нэр дэвшихээр болсон нь олон нийтийн санаа бодлыг өөртөө татаж чадаагүй гэсэн томоохон шүүмжлэлийг хүлээгээд байна.

Мөн түүнээс гадна Камала өнгөрсөн жилүүдэд АНУ-ын дэд ерөнхийлөгчөөр ажилласан бөгөөд өмнөх засгийн газарт хэт их хууль бус цагаачдыг чөлөөтэй нэвтрүүлэх бодлого баримталж нийгмийн эмзэг ядуу давхаргад очих ёстой байсан халамжийг хилээр орж ирсэн хууль бус цагаачид руу шилжүүлэх, задгай хилийн бодлого явуулах болсон зэрэг асуудал нь олон нийтийн дургүйцлийг ихээр хүргэж байв. Камала Харрисыг ардчилсан намаас нэр дэвшүүлэхээр

сонгосон хамгийн том шалтгаан бол АНУ-ын хар арьст давхарга болон эмэгтэйчүүдийн саналыг авах зорилготой байсан боловч сонгуулийн дүн гарахад Камала харин ч дээрх давхаргын эгдүүцэл дургүйцлийг хүргэсэн нь нэгэнт илт болсон юм. Дээр дурдсанчлан АНУ-ын хар арьст иргэд ядуу буурай нийгмийн эмзэг давхаргын ихэнх хувийг эзлэх бөгөөд энэхүү давхаргад очих ёстой нийгмийн халамж, хоол хүнсний талоньг хилээр орж ирсэн хууль бус цагаачдад шилжүүлсэн нь энэхүү давхаргаас санал авч чадахгүйд хүргэсэн байна. Харин эмэгтэйчүүдээс санал аваагүй шалтгааныг АНУ-ын иргэд хараахан эмэгтэй ерөнхийлөгчтэй болоход бэлэн бус байгаа бөгөөд эмэгтэйчүүд түүний Сан Франциско хотын даргатай үүсгэсэн амрагийн асуудлыг хэзээ ч уучлахгүй гэсэн судалгааны дүн ч гарсан байв. Камала өмнө нь сонгуульд нэр дэвшиж байгаагүйгээр барахгүй хэзээ ч ялж үзээгүй нэгэн юм. АНУ-ын дэд ерөнхийлөгч нь албан үүргийн хуваарилалтаар АНУ-ын хилийн аюулгүй байдлыг хариуцдаг боловч хил дээр ганц ч удаа очиж үзээгүй, үүнийгээ твийн ярилцлагад хэлснээр бас нэгэн ялагдах том шалтгаан болсон байна.

Доналд Трамп ялсан шалтгаан:

Америкийн Нэгдсэн Улсын хилээр хууль бусаар цагаачид олноор орж ирэх болсон бөгөөд

өнөөдөр ч энэхүү “гамшигт үзэгдэл” Америкт үргэлжилж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама болон Дональд Трамп нар аль аль нь тус улсын ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа хилийн дээрх хууль бус цагаачдын асуудлыг “Энэ бол гамшиг” хэмээн нэрийдэж байжээ.

Энэ ч утгаараа Д.Трамп АНУ-ын 47 дахь ерөнхийлөгч болон дахин сонгогдож чадсан гэж үзэж болно. Тэрээр АНУ-руу хууль бус цагаачид олноороо хил зөрчин ирж байгааг таслан зогсооно гэдгээ мэдэгдэхийн зэрэгцээ хил дээрх хүний наймаа, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, хар тамхины наймааны сүлжээ зэргийг таслан зогсоож цаашид мексикийн хана барих ажлыг зарим эх сурвалжууд “Трампын хана” гэж бичиж байгааг дуусгавар болгон Аврора хэмээх хууль бус цагаачдыг олноор нь баривчлан нутаг буцаах ажиллагаа эхлүүлнэ гэдгээ амлаад байсан нь ялах томоохон шалтгаан болсон гэж судлаачид үзэж байна.

Жоё Байдены засгийн газрын үед баримталсан задгай хилийн бодлого:

2021 оны 1 дүгээр сард АНУ-ын 46 дахь ерөнхийлөгч Жоё Байден ерөнхийлөгчийн тангараг өргөснөөр түүний засаг захиргаа үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тэрээр ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа АНУ хил дээр үндсэндээ “Задгай хилийн бодлого” явуулж

эхэлсэн гэж хэлж болно. Түүнийг ерөнхийлөгч байх хугацаанд нийтдээ 13 сая гаруй хууль бус цагаачид хилээр нэвтрэн орсон бөгөөд үүнийгээ дагаад ард иргэдийн амгалан тайван байдал алдагдаж гэмт хэргийн гаралт АНУ даяар эрс өссөн үзүүлэлттэй байв. Хүний наймаа, хар тамхины хэрэглээ бүр гаарч цэргийн насны хөдөлмөрийн насны АНУ-ын хүүхэд залуусын 57 хувь нь цэрэгт алба хаах боломжгүй болсон гэсэн судалгаа ч гарч байв. Ж.Байден үүнийгээ тайлбарлахдаа хүн нэмэгдвэл хүнс нэмэгдэж эдийн засаг тэлэх болно, нэгэнтээ хилээр орж ирсэн гадаадын иргэдийн хүний эрх, эрх чөлөөг бид хангах үүрэгтэй АНУ бол дэлхий дахинд ардчиллын үлгэр дуурайлал болж харуулах ёстой зэргээр өөрийн бодлогыг өмгөөлж байв. Гэвч америкийн хилээр нэвтрэн орж ирэгсдийн дотор үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц Венесуелийн Tren de Aragua мафийн бүлэглэл, Элсалвадорийн MC13 бүлэглэл, Колумбийн картел, Мексикийн картелууд АНУ-руу шилжин байрласан нь нэгэнт тагнуулын байгууллагуудын рапортод ил болсон байна. Түүгээр ч зогсохгүй цэргийн тагнуулын болон тагнуулын ажилтнууд олноороо түүн дотор бүртгэгдсэн байгаа нь тагнуулын байгууллагын санааг хамгийн ихээр зовоож байв. Зарим судлаачдын үзэж буйгаар Ж.Байдены засгийн газрын үед дэлхийн 3 дугаар дайн дэгдэхэд

хамгийн өндөр магадлалтай болоод байсан бөгөөд хилээр орж ирсэн хууль бус цагаачдыг АНУ-ын төлөө байлдуулахад ашиглах зорилготой гэх зэргээр хүртэл бичиж байв.

Хил дээрх хүний наймааны асуудал:

Өнгөрсөн хугацаанд АНУ-ын хилээр хууль бус цагаачид олноороо хил зөрчин орж ирэхийн зэрэгцээ тэдний 325 мянган хүүхэд ор сураггүй алга болсон бөгөөд эдгээр хүүхдүүдийг хүний наймаа бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтний наймааны золиос болсон гэж үзэж байгаа юм. Д.Трамп зүгээр ч нэг хилээр орж ирэх хууль бус цагаачдын урсгалыг таслан зогсоох гээгүй бөгөөд тэдгээр хууль бус цагаачдыг ашиглан хүний наймааны томоохон мафийн сүлжээ бий болсныг илрүүлж цаашид энэхүү сүлжээний үйл ажиллагааг таслан зогсоохоор зорьж буй нь түүний сонгуульд ялах болсон томоохон шалтгааны нэг юм гэж хэлж болно. АНУ-д энэ тухай Алехандро Гомезын найруулсан sound of freedom хэмээх кино 2023 онд олон нийтэд цацагдсан бөгөөд энэхүү тойрсон олон хэрэг явдлууд өрнөх болов. Тус кинонд хүний наймааны золиос болсон хүүхдүүдийн тухай гарах бөгөөд киноны багийнханд олон төрлийн улс төрийн дарамт шахалтууд ирж Япон улсад гэхэд л 1 жилийн дараа кино театруудад гаргах эрх олгож байв. Дэлхий даяар жилд 2

сая гаруй хүүхэд хулгайлагдаж хүний наймааны золиос болдог гэсэн судалгаа байдаг бөгөөд энэхүү золиос болсон хүүхдүүд Эпстейн арлын хэрэг явдалд гардагчлан баян эрчүүдийн зугаа цэнгэл болохоор аль нэг АНУ-ын арлууд руу зарагддаг байх магадлал тун өндөр юм.

АНУ сулрах болсон шалтгаан:

Либерализм анархизм болж хэт дур зоргоор аашлах байдал хүн амын дунд болон улс төрд газар авсан нь энэ үндэстнийг цаашид мөхөөх ч аюултай гэж зарим судлаачид үзэх болсон байна. Ардчиллын нэгэн сул тал бол хагарал талцлыг өрдөх хамгийн амархан нийгмийн тогтолцоог ардчилсан нийгэм гэж үздэг байна. АНУ суларсан бас нэгэн том шалтгаан нь сүүлийн 30 жилийн хугацаанд өөрийнхөө эсрэг хэтэрхий олон дайсныг дэлхий даяар бэлдсэн явдал бөгөөд олон фронт дээр зэрэг байлдахгүй гэсэн Сталины зарчмыг зөрчсөнтэй ч холбоотой гэж тайлбарлах болжээ. Нийгмийн хагарал талцал хирээс хэтэрч зэвсэгт бүлэглэлүүдийн тэмцэл цаашлаад АНУ-д иргэний дайн дэгдэх магадлал түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрснийг бид black lives matter хөдөлгөөний үеэр бэлхнээ харсан гэж хэлж болно. Өнөөдөр АНУ-д идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг зэвсэгт бүлэглэлүүдийг нэрлэвэл Team Red, White & Blue хэмээх бүлэглэл байдаг бөгөөд энэхүү бүлэглэлд

бүртгэлтэй 250 мянга гаруй бүрэн зэвсэглэсэн гишүүд байдаг байна. Түүнээс гадна хар тамхины хамааралтай хүн амын тоо хэт их өсөх болсон нь цагаан тахал гэгддэг мансууруулах төрлийн бодисоор дамжуулан Америкийн агуу үндэстнийг устаж үгүй болох аюул нүүрлээд байна гэж хэлж болно. Тус улсын хүн амын 70 орчим хувийг христийн шашинд итгэгчид эзлэх бөгөөд христийн шашны үндсэн үзэл санааг гажуудуулж “Алдас” болох LGBTQ-ийн асуудал хирээс хэтэрсэн нь Д.Трампын эгдүүцлийг төрүүлэх болсон бөгөөд Зэвсэгт хүчинд алба хаадаг 13 мянга гаруй дээрх төрлийн офицер ахлагч нарыг бэлтгэлээр халж, боловсролын яамны сургалтын тогтолцоонд өөрчлөлт хийх зорилгоор тараах болсон байна.

Department of Homeland Security:

АНУ-ын United States Department of Homeland Security хэмээх энэхүү байгууллага нь нэгдсэн улсын засгийн газрын агентлагуудын нэг бөгөөд тус улсын хил хамгаалалт, хилийн аюулгүй байдал, хилийн хяналт, хил орчмын бүс нутгийн байгаль орчны асуудал, гадаад иргэн харьяатын асуудал, нэгдсэн улсын чухал албан тушаалтнуудын биет хамгаалалт зэргийг хариуцдаг нэгэн өвөрмөц байгууллага юм. Тус агентлагийг анх 2001 оны 09 дүгээр сарын 11-ний хэрэг явдлаас хойш байгуулах санал

санаачилгууд гарах болсон бөгөөд дээрх хэрэг явдал нь АНУ-ын эх газрыг гаднын халдлагаас хамгаалж чадаагүй хэмээх томоохон шүүмжлэлээс үүдэн 2002 оны 11 дүгээр сард байгуулах болжээ. Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын хамгийн залуу агентлаг бөгөөд үйл ажиллагааны цар хүрээгээр тус улсад 3 дугаарт ордог томоохон байгууллага гэж хэлж болно.

Доналд Трамп АНУ-ын 47 дахь ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа тус улсын өмнөд хил дээр баримтлах бодлогыг чангатгаж Мексикийн хана барих ажлыг түргэвчилж, түүхэнд байгаагүй томоохон “Аврора ажиллагаа” буюу хууль бус цагаачдыг баривчлан нутаг буцаах ажиллагааг эхлүүлэхээ зарлаад байгаа юм. Өнөөдрийн байдлаар АНУ-ын хилийг зөрчин орж ирсэн хууль бус цагаачид тус улсад орогнох асуудал маш их хүндэрсэн бөгөөд Department of Homeland Security байгууллагын мэдэгдэж буйгаар АНУ-ын хилээр нэвтрэн ирэхийн тулд та аюулгүй, хууль ёсны, дэг журамтай замыг ашиглах ёстой гэжээ. Тус улсын хилийн нэвтрэхдээ хууль ёсоор нэвтрээгүй тохиолдолд дахин хилээр нэвтрэх эрхийг нь түдгэлзүүлэхээс гадна АНУ-д дахин 5 жилийн хугацаанд зорчих үед хүлээн авахаас татгалзах дахин хууль бусаар хил нэвтрэхийг оролдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

хүртэл арга хэмжээ авдаг байна. АНУ-ын хилийн аюулгүй байдлыг хариуцдаг нэгж HSD-ийн талаар бас нэгэн баримт дурдахад энэ байгууллагад чухал хүний хамгаалалт буюу төрийн тусгай хамгаалалтын газар харьяалагддаг бөгөөд өнгөрсөн онд зохион байгуулагдсан ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Д.Трампыг 7 дугаар сар, 9 дүгээр саруудад 2 ч удаа буудахыг завдсан билээ. Түүнийг хамгаалах тусгай хамгаалалтын ажиллагааг муу зохион байгуулсан хэмээн тус агентлагийн дарга Кристи Нозмийг ажлаас нь халах болсон бөгөөд түүгээр ч зогсохгүй тус агентлагийн 100 гаруй удирдах албан тушаалтныг ажлаас нь чөлөөлөхөөр бэлтгэл ажлаа хангаж байна.

Монгол улс ч ижил төстэй аюул занал дунд оршин тогтнож байна

Сүүлийн 30 гаруй жил даяарчлалын шуурганд цохигдон явсаар ирсэн Монгол Улсын хувьд АНУ-ын асуудал нэгэнтээ бусдын асуудал биш болжээ. Ардчилал хүний эрх, эрх чөлөөгөөр халхавчлан нийгмийн бүхий л давхаргад хагарал талцал нүүрлэж, Монгол хүмүүс багаар ажиллах чадамж муудсан бөгөөд өнөөдрийн байдлаар хар тамхи, алкохол мансууруулах бодисын хэрэглээгээр дэлхийд өнөөдөр 4 дүгээрт явж байгаа нь аюулын харангыг маш чангаар дэлдэж байна гэж хэлж болно. Хүний наймааны асуудал ч нэгэнтээ

Монгол Улсыг тойроогүй дайрч байгааг бид хэвлэл мэдээллийн сувгаас олж мэдэх боломжтой болжээ. Цар тахлын 2 жилийн хугацаанд хил хаалттай байсан бөгөөд дээрх төрлийн гэмт хэргүүд нэгэнт зогсонги байдалд орсон тухай цагдаагийн байгууллага болон хил орчмын бүс нутагт амьдардаг ард иргэд ил тод ярих болов.

Дүгнэлт, санал

Дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн гэгддэг Америкийн нэгдсэн улсад ч хилийн аюулгүй байдал ноцтойгоор алдагдаж улмаар тус улсын үндэсний аюулгүй байдал алдагдах болсныг бид бүхэн тодорхой тоон дүн статистикаар харлаа. Дэлхийн хамгийн

Эх сурвалж

1. “Why Kamala Harris lost: A flawed candidate or doomed campaign?” , BBC. 2024. <https://www.bbc.com/news/articles/cjr4l5j2v9do>, (2024.11.07);
2. “U.S. Department of Homeland Security” , 2025. <https://www.dhs.gov/>, (2025.04.01);
3. “Globalization”, National geographic, 2024, <https://education.nationalgeographic.org/resource/globalization/>, (2025.04.01);
4. “Five reasons why Donald Trump won the US election”, Victoria University of Wellington. 2024.

хүчирхэг цэрэг арми, технологитой улс хил гаалийн аюулгүй байдлаа алдсанаар Хил амгалан бол улс амгалан гэсэн үндсэн зарчим үйлчилж байхад дэлхийд эдийн засгийн чадавхаараа 124 дүгээрт, хүн амын тоогоор 195 улсаас 133 дугаарт эрэмбэлэгдэж байгаа нь яахын аргагүй жижиг улсад тооцогдох юм. Их гүрнүүд ч тогтоон барьж дийлэхгүй байгаа энэхүү хилийн аюулгүй байдлыг бид цаашид хэрхэн тогтоон барих аюулгүй, занал, эрсдэлийг үгүй хийх вэ гэдэг дээр шинэ тутам үүсэн хөгжиж буй хил судлалын шинжлэх ухааныг чиглүүлэх нь зүйтэй болов уу гэж судлаач миний хувьд үзэж байна.

- https://www.wgtn.ac.nz/news/2024/11/five-reasons-why-donald-trump-won-the-us-election_, (2025.04.01);
5. “Why is the US becoming a weak and crippled society day by day?” , Quora. 2024. <https://www.quora.com/Why-is-the-US-becoming-a-weak-and-crippled-society-day-by-day>, (2025.04.01);
 6. “How Porous Borders Fuel Human Trafficking in the United States” , Texas public and policy foundation. 2023 <https://www.congress.gov/118/meeting/house/116344/documents/HHRG-118-JU08-20230913-SD003.pdf>, (2025.04.01);